



# “Улаанбаатар Аудит корпораци” ХХК

## АУДИТЫН ТАЙЛАН

---

“МҮДИКС” ХК-ийн 2012 оны 12 дугаар сарын  
31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн  
тухай

2013 оны 2 дугаар сар

Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,  
Их тойруу, Маргад центр төв  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-11-321844, 329430, 70110744  
Факс: 976-11-321844



20 13 оны 02 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар #1/13-024

Утас: 321844, 329430, 70110744  
Факс: 976-11-321844  
Шуудан: “Mongol Post” LLC  
Имэйл хаяг: ubaudit\_corp@mongol.net  
Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “МУДИКС” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

#### Оршил

Бид “Мүдикс” ХК (цаашид “компани” гэх) 2012 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

#### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

#### Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид Аудитаа Олон Улсын Стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

#### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр “Мүдикс” ХК-ийн 2012 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Хүндэтгэсэн:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б. ОСОРГАРАВ

“МУДИКС” ХК

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2012 оны 12 сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2011	2012
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	64,740.1	535.9
Дансны авлага	4	418,911.0	438,511.5
Бусад авлага	4		74,107.7
Бараа материал	5	21,546.0	21,546.0
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>505,197.1</b>	<b>534,701.1</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө /цэвэр/	6	948.8	603.8
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>948.8</b>	<b>603.8</b>
		<b>506,145.8</b>	<b>535,304.9</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
<b>Өр төлбөр</b>			
Богино хугацаат өр төлбөр	7	444,995.6	453,665.5
<b>Өр төлбөрийн дүн</b>		<b>444,995.6</b>	<b>453,665.5</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>			
Энгийн хувьцаа	8	38,569.2	38,569.2
Хуримтлагдсан ашиг/алдагдал/		22,581.0	43,070.2
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>61,150.2</b>	<b>81,639.4</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>506,145.8</b>	<b>535,304.9</b>

*Нэмэлт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.*

**“МУДИКС” ХК**

**ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

2012 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон жилийн хувьд  
(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2011	2012
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>			
Борлуулалтын орлого	9	1,067.3	
<b>Нийт ашиг</b>		<b>1,067.3</b>	-
Үйл ажиллагааны зардал	10	(29,743.2)	(67,676.3)
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг, (алдагдал)</b>		<b>(28,675.9)</b>	<b>(67,676.3)</b>
Хүүгийн орлого	11	58,166.8	102,930.1
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг/алдагдал/	11	(1,093.2)	(4,459.8)
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, (алдагдал)</b>		<b>57,073.6</b>	<b>98,470.3</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>28,397.7</b>	<b>30,794.0</b>
Орлогын татварын зардал		(5,816.7)	10,304.8
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		<b>22,581.0</b>	<b>20,489.2</b>
Нэгж хувьцаанд ноогдох нийт ашиг		0.3	0.2

*Нэмэлт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.*

**“МҮДИКС” ХК**

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2012 оны 12 сарын 31-ний байдлаар дуусгавар болсон жилийн хувьд  
(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Хувьцаат капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2010 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>38,569.2</b>		<b>25,532.0</b>	<b>64,101.2</b>
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт/				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз , /гарз/			2,951.0	<b>2,951.0</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				-
<b>2011 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>38,569.2</b>	-	<b>22581.0</b>	<b>61,150.2</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз , /гарз/				
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	20,489.2	<b>20,489.2</b>
Ногдол ашиг	-	-		-
Гаргасан хувьцаат капитал	-			-
<b>2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>38,569.2</b>	-	<b>43,070.2</b>	<b>81,639.4</b>

*Нэмэлт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салиггүй хэсэг болно.*

**“МУДИКС” ХК**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2012 оны 12 сарын 31-ний байдлаар дуусгавар болсон жилийн хувьд  
(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2011	2012
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>1,382.8</b>	<b>-</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	1,067.3	
Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө		
Бусад	315.5	
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>417,830.6</b>	<b>(94,089.2)</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	4,680.0	13,825.8
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	390.6	4,543.6
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	21,546.0	
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		320.1
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл, холбоонд төлсөн мөнгө	4.0	1,480.0
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	390,918.9	20,355.0
Төлсөн хүү		34,594.0
Төлсөн татвар	291.1	13,405.6
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад		5,565.1
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(417,830.6)</b>	<b>(94,089.2)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого		-
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(1,035.0)	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,035.0)</b>	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөөр эргүүлж худалдан авсан хувьцаа	38,569.2	
Банкнаас авсан зээл/Хөрөнгө оруулагчаас зээл/	385,692.0	
Зээлийн төлөлт	(2,114.2)	
Хүү ба урамшууллын орлого	57,750.0	29,885.0
Валютын ханшны зөрүү	1,093.2	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>480,990.2</b>	<b>29,885.0</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>63,507.4</b>	<b>(64,204.2)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,232.7</b>	<b>64,740.1</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>64,740.1</b>	<b>535.9</b>

*Нэмэлт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.*